

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, төлөвлөгөө, тайлан
хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэнддорж Ганхуяг
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэл тийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	
	1	2	3	4	5	6	7
1.1. Байгууллагын хүний нөөцийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангана.							
1	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, батлуулах, 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, %	2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100 %	90 %	Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2025-2028 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд 2025 онд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хугацаа хүлээгдэж байна. Аймгийн Төрийн албан хаагчдын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нийгмийн дэмжлэгт хамрагдах 2 албан хаагчийн холбогдох материалыг бүрдүүлэн аймгийн ЗДТГазрын ТЗУХэлтэст хүргүүлсэн. Төрийн захиргааны 1 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг 15 хувиар олгох, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5 албан хаагчид олгох шийдвэрийг тус тус гаргуулан	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	90%

					ажиллав. Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2025 оны "Бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай" А/02 дугаар тушаалыг үндэслэн 2 сул орон тоо, жирэмсний болон амарсны амралттай 1 орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөн бүрдүүлсэн.		
2	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, %	Сургалтын төлөвлөгөөний 2024 оны хэрэгжилт 100 хувь.	80%	Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан хаагчдыг чадавхжуулах 2025-2028 оны сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж батлуулсан. Хөтөлбөрийг 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг албан хаагчдыг чадавхжуулах, гадагш чиглэсэн сургалт гэсэн 2 төрлөөр боловсруулж, нийт 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хэрэгжилтийн тайланг 6 дугаар сарын 12 нд нэгтгэн гаргахаар хугацаа хүлээгдэж байна. нар "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ын хүрээнд 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, бэлтгэл хангах зорилгоор Монгол бичгийн анхан, дунд шатны хөтөлбөрөөр байгууллагын албан хаагчдад мэдлэг олгох, чадавхжуулах, мэргэшүүлэх 450 минутын 10 удаагийн хичээлийг аймгийн Боловсролын газартай хамтран зохион байгуулсан. Багшийн зүгээс хичээлийн үр дүнд үнэлгээг өгөхөд 91.7 хувьтай дүгнэгдсэн. Аймгийн Төрийн архивын газраас зохион байгуулсан байгууллагуудын Архив, бичиг хэргийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад холбогдох албан хаагчийг хамруулан чадавхжуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 8 сургалтад давхардсан тоогоор 94 албан	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хаагчийг танхим, цахимаар хамруулан оролцуулж мэдлэг олгосон.		
3	Төрийн албаны: зөвлөл, салбар зөвлөлөөс батлагдсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангах, арга хэмжээ, үйл ажиллагааг зохион байгуулж, байгууллагын албан хаагчдад тухай бүрд мэдээлэх, танилцуулах, тайлагнах	Холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хувь, %	100%	100%	Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим санд албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулж, албан хаагчдаар хянуулан баталгаажуулж ажилласан. Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн аймгийн Төрийн албан хаагчийн хөгжлийн хөтөлбөрийн нийгмийн дэмжлэгт хамруулахаар 2 албан хаагчийн материалыг бүрдүүлэн хүргүүлсэн.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
4	Хүний нөөцийн талаар гаргах тушаал, шийдвэрийн төслийг боловсруулах, батлуулах	Батлуулсан тушаал шийдвэрийн хэрэгжилтийн хувь, %	-	100%	Хүний нөөцийн томилгоо, цалин хөлс, нэмэгдэл олгох, хөтөлбөр батлуулах чиглэлээр Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус байнгын ажиллагаатай комисс томилох тухай, Зэрэг дэвийн нэмэгдэл олгох тухай, 2025 оны ээлжийн амралтын хуваарь батлах тухай, Жирэмсний болон амаржсаны амралт олгох тухай, Төрийн захиргааны албан тушаалд шилжүүлэн томилох тухай 2, Түр орлон гүйцэтгэгчээр томилуулан ажиллуулах тухай, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай, Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт батлах тухай, Хөтөлбөр батлах тухай 2, гэх мэт нийт 10 тушаалын төслийг боловсруулан холбогдох албан тушаалтнуудаар хянуулан батлуулсан.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
5	Ёс зүйн дэд хорооны 2025 онд ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, %	-	90%	Байгууллагын ёс зүйн дэд хорооноос 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 1 улаагийн танхимын, 1 удаагийн цахим	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

	зохион байгуулж ажиллах				сургалт, 1 удаагийн аяныг зохион байгуулсан.	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
6	Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авах, бүртгэх, хянах, баталгаажуулах, тайлагнах ажлыг зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь, %	100%	100%	2024 оны ХАСХОМ-ийг нийт 7 албан хаагчаас хуулийн хугацаанд хүлээн авч, хянан баталгаажуулсан. Албан тушаал дэвших 1, түр орлон гүйцэтгэхээр томилогдох 1, нийт 2 хүний ХАСУМ-ийг Авлигатай тэмцэх газраар хянуулж, дүгнэлтийг үндэслэн томилгоог хийсэн. Мөн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь гаргуулан хянан баталгаажуулж ажилласан. Аймгийн ЗДТГазар, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох 2 удаагийн цахим сургалтад мэдүүлэг гаргагч болон төрийн захиргааны давхардсан тоогоор 22 албан хаагчийг хамруулан мэдлэг олгосон.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2.1. Байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангах хүрээнд Шил ажиллагааны цахим системд холбогдох тайланг илгээх ажлыг зохион байгуулах							
7	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах	Хэрэгжилтийн хувь, %	99.7%	85%	Тайлагнах хугацаа хүлээгдэж байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	0%
8	Шил ажиллагааны цахим системд холбогдох	Тайлагналтын хувь, %	96.1%	85%	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн	2-р сар, 3-р сар, 4-р	100%

	тайлагналтыг хийж ажиллах				албан хаагчийн хувийн хэргийг хөтлөх журам"-ын хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын нийт албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг нягтлан шалгаж, нөхөн бүодүүлэлт хийн ажилласан. Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сангийн 7179, 7180 дугаарт бүртгэгдсэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 402, 498 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим санд албан хаагчдын мэдээллийг шинэчлэн, баталгаажуулах, албан тушаалын тодорхойлолтыг оруулан Төрийн албаны зөвлөлөөр хянуулан баталгаажуулах ажлыг заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн.	сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
3.1. Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.							
9	Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүгийг хэрэгжүүлэн ажиллах	Хэрэгжилтийн хувь, %	100%	100%	Үйл ажиллагаандаа албан тушаалын тодорхойлолтод заасан болон байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж, ямар нэгэн ёс зүй, хариуцлагын зөрчилгүй ажилласан.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Монгол бичгийн сургалтад хамрагдах, бичих чадварыг сайжруулах	Төлөвлөж буй албан бичгийг монгол бичгээр хөрвүүлсэн хувь, %	2024 онд сургалтад хамрагдаагүй. Унших чадвар дундаас дээш түвшинд эзэмшсэн.	100%	Байгууллагаас зохион байгуулсан Монгол бичгийн сургалтад хамрагдан хөрвүүлэх, галигийг үндэсний бичгээр хөрвүүлэх, унших, Компьютерт бичих чадварыг эзэмшсэн. Багшийн зүгээс сургалтын чанарыг үнэлэхэд үнэлгээний дундаж 93 хувьтай дүгнэгдсэн.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
2	Хариуцаж буй албан чиг үүргийн дагуу суралцах	Сургалтын тоо	-	1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулж буй Менторшип хөтөлбөрт Менти болохоор хамрагдан суралцаж байна. Мөн Төрийн албаны зөвлөл, аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан 1 удаагийн танхимын, 1 удаагийн цахим сургалтад хамрагдан Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн мэдээллийг шинэчлэн ажилласан.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүний нөөц, сургалт, сурталчилгаа, төлөвлөгөө, тайлан хариуцсан ахлах мэргэжилтэн, Цэнддорж Ганхуяг

/...../

Огноо: 2025.06.10